

Тайванийн Экспорт импортын банкны зээлийн шугамтай холбогдох асуулт, хариултууд

/Хятад болон Англи дээрхи эх материалын эхийг үндэслэнэ. /

Асуулт 1: Санхүүжилтийн зээл (Relending Facility) гэж юу вэ?

Хариулт: Өнөөгийн нөхцөл байдалд зарим бүс нутагт гадаад валют дутагдалтай буйгаас үүдэн тухайн орны импортлогч, бизнес эрхлэгчид гадаад валютын санхүүжилт хийхэд хүндрэлтэй, харилцагч банкнаас зээл авахад өртөг өндөр тусдаг тул Тайванийн Эксим банкны зүгээс санхүүжилтийн зээл олгох асуудлыг эрчимжүүлэн, санхүүжилтийн зээлийн шугамын гэрээ байгуулсанаар гадаад дотоодын банк санхүүгийн байгууллагад ам.долларын зээлийн квот олгох болсон. Ингэснээр санхүүжилтийн зээлэнд хамрагдаж буй гадны улс орны бизнес эрхлэгч нар Тайваниас экспортлож буй бараа бүтээгдэхүүнийг худалдан авах боломж бүрдэв. Бизнес эрхлэгчид энэхүү хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр графикын дагуу зээлээ төлж барагдуулах бөгөөд энэхүү санхүүжилтийн зээлээр дамжуулан гадны бизнес эрхлэгчдийн Тайваниас худалдан авалт хийх сонирхолыг дээшлүүлэх боломжтой. Тайванийн экспортлогч бизнес эрхлэгчид бараа ачиж бэлтгэн, нэхэмжлэх бэлэн болсоны дараа барааны нийт төлбөрийг хүлээн авах боломжтой. Өөрөөр хэлбэл санхүүжилтийн зээл нь экспортыг дэмжих банк санхүүгийн туслах хэрэгсэл болно.

Асуулт 2: Засгийн газраас “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа. Энэхүү хөтөлбөрийн агуулга нь юу вэ?

Хариулт: “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Эдийн засгийн яам болон Тайванийн Эксим банк нь “Санхүүжилтийн бэлтгэл сан”-г хамтран байгуулсан. Ингэснээр дэлхий даяар санхүүжилтийн зээл олгох чиглэлээр хамтран ажиллах улс орон болон байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн, Тайванийн экспортлогч бизнес эрхлэгчид нь санхүүжилтийн зээл олгогч нартай тогтоосон харилцааг оновчтой ашиглан, харилцагч нарынхаа хүрээг тэлэх боломжтой бөгөөд дэлхийн зах зээлд нэвтрэн, экспортын моментыг хадгалж, Тайванийн эдийн засгийн хөгжүүлэх сайн талтай.

Асуулт 3: Экспортлогч бизнес эрхлэгчид энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдах хүсэлтээ хэрхэн гаргах вэ?

Хариулт: Энэхүү санхүүжилтийн зээлийг Тайванийн Эксим банкнаас гадаад орнуудын зээлийн шугам бүхий банкууд олгох бөгөөд тухайн улсад байгаа импортлогчид нь санхүүжилтийн зээлэнд хамрагдах ба экспортлогч Тайванийн Эксим банканд зээлийн хүсэлт гаргах шаардлагагүй. Харин экспортлогч бизнес

эрхлэгч нь бичгээр эсвэл амаар гадаадын импортлогчид Тайванийн Эксим банкны зээлийг танилцуулан, энэхүү санхүүжилтийн зээлийг олгодог банкуудын нэрсийн жагсаалтыг гарган өгнө.

Санхүүжилтийн зээлийн тухай мэдээлэл бүхий Англи хэл дээрхи цахим хуудас: <http://www.eximbank.com.tw/english/pages/detail.aspx?Node=169&Page=465>

Экспортлогч талын зүгээс ямар нэгэн баримт бичиг бүрдүүлэн батлуулах болон ямар нэгэн төлбөр төлөх шаардлагагүй бөгөөд бүрдүүлэх бичиг баримт ч маш хялбар дөхөм болно.

Асуулт 4: Санхүүжилтийн зээл нь экспортлогчид хэрхэн дэмжлэг үзүүлдэг вэ?

Хариулт: Тайванийн Эксим банк нь тухайн орны санхүүжилтийн зээлийн шугам нээсэн банкуудад тухайн улсын зах зээлийн ханшаас доогуур хувийн хүүтэй зээл олгох замаар импортлогчид энэхүү зээлийг олгоно. Энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдагч нь зөвхөн Тайваниас бараа импортлох тухай журманд тусгасан. Иймд Тайванийн экспортлогчид нь гадаад зах зээлээ өргөжүүлэх үедээ импортлогчид: “Хэрэв та манай компаниас худалдан авалт хийвэл, хөнгөлөлттэй графикт төлөлтийн нөхцөлөөр худалдан авалт хийх боломжтой” гэж тайлбар хийх боломжтой. Импортлогч нь тухайн газар оронд хөрөнгө хомсдолтой байгаа нөхцөлд Тайванийн Эксим банкнаас олгож буй тогтвортой хөрөнгийн санхүүжилтэнд түшиглэн, Тайванийн экспортлогч нараас худалдан авалт хийхийг хүсэх нь дамжиггүй. Үүний зэрэгцээ Тайванийн экспортлогчид ч бас олон улсын зах зээл дээрхи өрсөлдөх чадавхиа нэмэгдүүлэх боломжтой юм.

Асуулт 5: Импортлогч нь энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдах хүсэлтээ хэрхэн гаргах вэ? Зээл авах эрхэнд онцгой хягаарлалт тавигдах уу?

Хариулт: Тайваниас худалдан авалт хийж, бараа импортоор авч буй импортлогчид нь өөрийн улс дахь санхүүжилтийн зээлийн шугам бүхий банкнаас энэхүү санхүүжилтийн зээлийг авах хүсэлт гаргах боломжтой. Тухайн улсад байх санхүүжилтийн зээлийн шугам бүхий банкны зүгээс импортологчид төлөх үнийн дүнг хянан шалгана. Хэрэв импортлогчийн харилцагч банк нь Тайванийн Эксим банкны санхүүжилтийн зээлийн шугамын гэрээ байгуулсан банкны нэрсийн жагсаалтанд багтаагүй тохиолдолд импортлогчийн зүгээс харилцагч банкны холбоо барих хүний мэдээллийг Тайванийн Эксим банканд гарган өгч болох ба Тайванийн Эксим банкны зүгээс уг банктай санхүүжилтийн зээлийн хамтын ажиллагааны асуудлаар нэн даруй яриа хэлэлцээ хийх боломжтой.

Асуулт 6: Экспортлогчид нь энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдан, экспорт хийх боломжтой юу?

Хариулт: Энэхүү санхүүжилтийн зээлийг голдуу Тайванийн Эксим банкны зүгээс импортологчийн харилцагч банкуудад бага хүүтэйгээр олгодог бөгөөд Тайваниас

худалдан авалт хийн, бараа импортоор авч буй импортлогчид энэхүү санхүүжилтийн зээлийг олгох ба экспортлогчид нь шууд бус хэлбэрээр энэхүү санхүүжилтийн зээлийн үр шимийг хүртдэг. Иймд экспортлогчид нь Тайванийн Эксим банкнаас шууд экспортын зээл авдаггүй болно. Тайванийн Эксим банкны санхүүжилтийн зээлийн үйл ажиллагааны зохицуулалт нь импортлогчид харьцангуй бага хүүтэй санхүүжилтийн зээл олгож, Тайванийн экспортлогчдын барааны төлбөрийг хийхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд хөрөнгийн урсгалын хувьд Тайванийн экспортлогчид нь хэрэв барааны төлбөрөө шууд хүлээн авах сонирхолтой бол тооцооны баримтын дагуу барааны төлбөрөө хүлээн авах боломж олгодог. Тайванийн Эксим банк нь мөн “Экспортын зээл”-ийг олгож байгаа бөгөөд энэхүү экспортын зээлийг сонирхож байвал зээлийн асуудал хариуцсан албатай (02) 23218284 дугаараар шууд холбогдон мэдээлэл авах боломжтой.

Асуулт 7: Энэхүү санхүүжилтийн зээл нь экспортлогчид худалдааны эрсдэлээс зайлсхийх боломж олгодог уу?

Хариулт: Санхүүжилтийн зээл олгох зээлийн шугам бүхий банк нь гадаадын импортлогчид зээл авахаас өмнө уг компанид баталгаа гаргаж өгдөг /Импортлогчийн төлбөр төлөх эрсдэлийг санхүүжилтийн зээл олгогч банк хариуцна/. Тухайн гадны улс орон дахь банк нь импортлогч компанийн үйл ажиллагааны одоогийн байдал, төлбөр төлөлтийн түүх зэргийг судлана. Иймд импортлогчид санхүүжилтийн зээл хүсэх үед тухайн улс дахь банкнаас зээлийн хүсэлтийг батлан, уг компанийн үйл ажиллагаа хэвийн байгаа төдийгүй төлбөр төлөлтийн тал дээр ч эрсдэл бага болохыг батладаг.

Асуулт 8: Санхүүжилтийн зээл нь экспортлогчдын худалдааны өртгийг бууруулах боломжтой юу?

Хариулт: Уг санхүүжилтийн зээлийг энэхүү зээлийн шугамын гэрээ байгуулсан банкны зүгээс Тайванийн бараа бүтээгдэхүүн худалдан авч буй гадаад орны импортлогчид харьцангуй бага хүүтэй санхүүжилт олгох замаар олгодог бөгөөд ингэснээр импортлогч нарын Тайваниас худалдан авалт хийх сонирхолыг татан, экспортлогч нарт гадаад худалдааны эргэлтээ нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд ингэснээр холбогдох өртөг зардлыг бууруулж өгдөг.

Асуулт 9: Уг санхүүжилтийн зээлээр аль төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаж авах боломжтой вэ?

Хариулт: Энэхүү санхүүжилтийн зээлээр Тайваниас экспортлож буй техник тоног төхөөрөмж, сэлбэг, түүхий эд болон бусад бүх төрлийн бараа бүтээгдэхүүн худалдан авах боломжтой юм.

Асуулт 10: Санхүүжилтийн зээлийг импорлогчид олгохдоо хугацааны хувьд хязгаар тавьдаг уу?

Хариулт: Санхүүжилтийн зээлийн үргэлжлэх нийт хугацаа таван жил хүртэл үргэлжилнэ.

Асуулт 11: Экспортлогч бүс нутагт БНХАУ багтаж байгаа юу?

Хариулт: Одоогийн байдлаар Тайванийн Эксим банкнаас олгож буй санхүүжилтийн зээлийг зөвхөн Тайванийн бизнес эрхлэгч захиалга авсан нөхцөлд зээлэнд хамруулж байгаа. Өөрөөр хэлбэл Тайваньд захиалга аван, гуравдагч бүс нутаг экспортлогч болж буй /БНХАУ үүнд багтана/ гурван талт худалдааны хэлбэрээр худалдаа хийсэн ч энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдах боломжтой.

Асуулт 12: Санхүүжилтийн зээл нь зөвхөн хөгжиж буй орнуудад олгогдох уу? Европи болон Америк тивийн улс орнууд энэхүү санхүүжилтийн зээлэнд хамрагдах боломжтой юу?

Хариулт: Хөгжиж буй дийлэнхи бүс нутгийн улс орнууд ам.долларын зээл авахад хүндрэлтэй байдаг. Тухайн улс оронд зээл авахад гардаг зардал ч өндөр тусдаг. Импортлогчид өртөг өндөр буйгаас үүдэн, Тайванийн экспортлогч нараас бараа худалдан авах боломжгүй байдаг. Тайванийн экспортлогчдын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэхийн тулд санхүүжилтийн зээлийн шугам бүхий банкны зүгээс зээл олгон, Тайваниас худалдан авалт хийхэд дэмжлэг үзүүлдэг агаад ийм ч учраас дийлэнхи санхүүжилтийн зээл олгогч банкууд нь хөгжиж буй улс орнуудад төвлөрдөг. Гэхдээ Европи, АНУ зэрэг хөгжингүй улс орнууд ч бас санхүүжилтийн зээлийн шугам нээн хамтран ажиллах банкууд байгаа бөгөөд тэдгээр банкуудын өөрийн хөрөнгийн өртөг харьцангуй бага, харилцагчид ч харьцангуй цөөтэй байдаг.

Асуулт 13: Санхүүжилтийн зээлийн шугам бүхий банкуудын нэрсийн жагсаалтыг хаанаас мэдэх боломжтой вэ?

Хариулт: Тайванийн Эксим банкны цахим хуудас <http://www.eximbank.com.tw/> 「 Үйл ажиллагааны танилцуулга 」 -ийг сонгон 「 Санхүүжилтийн зээл 」 -ийг сонгох бөгөөд цахим хуудасны хамгийн доод хэсэгт шинэчлэгдсэн санхүүжилтийн зээлийн шугам бүхий банкуудын нэрсийн жагсаалтыг оруулсан байгаа.

Асуулт 14: Санхүүжилтийн зээлийн тухай лавлаж тодруулах мэдээллийн суваг ?

Хариулт: Санхүүжилтийн зээлтэй холбогдох асуултыг Санхүүгийн албаны гадаад үйл ажиллагаа хариуцсан тусгай шугам (02)23971505 руу холбогдон авах боломжтой. Үүний зэрэгцээ interbankloan@eximbank.com.tw хаяг руу цахим шуудан илгээн лавлах боломжтой.